

МЭДЭЭЛЛИЙН ЭЗНИЙ ЗӨВШӨӨРӨЛ

Энэхүү зөвшөөрөл нь Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу мэдээллийн эзнээс зөвшөөрөл авах тухай хуулийн зохицуулалтыг үндэслэсэн болно.

1. Мэдээллийн эзний мэдээлэл:

Эцэг (эх)-ийн нэр	
Өөрийн нэр	
Регистрийн дугаар (иргэний бүртгэлийн дугаар)	
Холбоо барих мэдээлэл	

2. Мэдээлэл хариуцагчийн мэдээлэл:

Мэдээлэл хариуцагчийн оноосон нэр	"Үндэсний давхар даатгал" ХК
Регистрийн дугаар	5885612
Холбоо барих мэдээлэл	Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө, 106 байр, Бизнес тауэр, 20 давхар Утас: 75770002

3. Мэдээлэл хариуцагчийн мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах, дамжуулах үндэслэл:

Компанийн тухай хуулийн 79, 81.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20.2, Засгийн газрын 2023 оны 85 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өмчит компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах нийтлэг журам"-д заасныг тус тус үндэслэн "Үндэсний давхар даатгал" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах.

4. Мэдээлэл хариуцагчийн цуглуулах, боловсруулах, ашиглах мэдээллийн жагсаалт:

- Сонгон шалгаруулалтад оролцохыг хүссэн өргөдөл;
- Төрийн албан хаагчийн анкет (Маягт №1);
- Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг (диплом)-ийн эх хувийг нотариатаар гэрчлүүлсэн хувь (гадаадад их, дээд сургууль төгссөн бол баталгаат орчуулгын хамт);
- Мэргэшүүлэх сургалтад хамрагдсан бол гэрчлэх баримт бичиг (компанийн засаглалын гэрчилгээний хуулбар болон бусад);
- Иргэний үнэмлэхийн хуулбар (иргэний үнэмлэхийн лавлагааг давхар хавсаргах);
- Ажилласан жилийг тооцох хөдөлмөрийн болон нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаа;
- Цээж зураг, 2 хувь (4х3-ийн хэмжээтэй бөгөөд нэг ширхэг нь анкет дээр наагдсан байх);
- Урьд ажиллаж байсан 2-оос доошгүй байгууллагын эрх бүхий албан тушаалтны ажил байдлын тодорхойлолт;
- Өөрийн мэдлэг, ур чадвараа илэрхийлж, ажил байдлаа тодорхойлсон хүсэлт;
- Шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр ял шийтгүүлж байсан эсэх лавлагаа (иргэний, эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тодорхойлолт, иргэний, эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тодорхойлолт);
- Банк, санхүүгийн байгууллагын хугацаа хэтэрсэн өр төлбөргүй тухай лавлагаа (Зээлийн мэдээллийн сангийн лавлагаа, шүүхийн шийдвэрээр бусдад өр төлбөргүй эсэх тодорхойлолт, Шүүхийн тусгай архивын лавлагаа);
- Холбогдох хууль тогтоомж, энэ зард заасан шаардлагыг хангаж байгаагаа илэрхийлсэн баталгааны хуудас болон тавигдах шаардлагуудыг хангасан талаарх нотлох баримт (Санхүүгийн зохицуулах хороо, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв зэрэг холбогдох байгууллагын лавлагаа, тодорхойлолт гэх мэт).

5. Мэдээлэл хариуцагч мэдээллийг боловсруулж, ашиглах хугацаа:

Цуглуулсан мэдээллийг энэхүү зөвшөөрлийг гаргасан өдрөөс эхлэн 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн гишүүнийг сонгох хүртэл хугацаагаар боловсруулж, ашиглана.

6. Мэдээлэл хариуцагчийн нийтэд ил болгох, бусдад дамжуулах мэдээллийн жагсаалт:

Д/д	Мэдээллийн жагсаалт	Нийтэд ил болгох (нийтэд ил болгох бол харгалзах хүснэгтэд + тэмдэглэгээ хийнэ)	Бусдад дамжуулах (бусдад дамжуулах бол харгалзах хүснэгтэд + тэмдэглэгээ хийнэ)
1	Төрийн албан хаагчийн анкет (Маягт №1);		+
2	Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг (диплом)-ийн эх хувийг нотариатаар гэрчлүүлсэн хувь (гадаадад их, дээд сургууль төгссөн бол баталгаат орчуулгын хамт);		+
3	Мэргэшүүлэх сургалтад хамрагдсан бол гэрчлэх баримт бичиг (компанийн засаглалын гэрчилгээний хуулбар болон бусад);		+
4	Иргэний үнэмлэхийн хуулбар (иргэний үнэмлэхийн лавлагааг давхар хавсаргах);		+
5	Ажилласан жилийг тооцох хөдөлмөрийн болон нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаа;		+
6	Урьд ажиллаж байсан 2-оос доошгүй байгууллагын эрх бүхий албан тушаалтны ажил байдлын тодорхойлолт;		+
7	Өөрийн мэдлэг, ур чадвараа илэрхийлж, ажил байдлаа тодорхойлсон хүсэлт;	+	+
8	Шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр ял шийтгүүлж байсан эсэх лавлагаа (иргэний, эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тодорхойлолт, иргэний, эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тодорхойлолт);		+
9	Банк, санхүүгийн байгууллагын хугацаа хэтэрсэн өр төлбөргүй тухай лавлагаа (Зээлийн мэдээллийн сангийн лавлагаа, шүүхийн шийдвэрээр бусдад өр төлбөргүй эсэх тодорхойлолт, Шүүхийн тусгай архивын лавлагаа);		+
10	Холбогдох хууль тогтоомж, энэ зард заасан шаардлагыг хангаж байгаагаа илэрхийлсэн баталгааны хуудас (word файлаар татаж авах) болон тавигдах шаардлагуудыг хангасан талаарх нотлох баримт (Санхүүгийн зохицуулах хороо, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв зэрэг холбогдох байгууллагын лавлагаа, тодорхойлолт гэх мэт).		+

Тайлбар: ТУЗ-ийн хараат бус гишүүн нь компанийн эрх бүхий албан тушаалтан тул түүнийг томилохдоо Санхүүгийн зохицуулах хороо, Авлигатай тэмцэх газраас холбогдох зөвшөөрлийг авсны дараа Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж, шийдвэрлүүлдэг. Мөн Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу ТУЗ-ийн гишүүний зарим мэдээллийг цахим хуудсандаа нээлттэй байршуулдаг.

Иймд эдгээр байгууллага, албан тушаалтанд мэдээллийг дамжуулж, зарим мэдээллийг нийтэд ил болгодог.

7. Мэдээллийн эзний зөвшөөрлөө цуцлах хэлбэр:

Мэдээллийг энэхүү зөвшөөрлийг гаргасан өдрөөс эхлэн 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн гишүүнийг сонгох хүртэл хугацаагаар боловсруулж, ашигласнаар мэдээллийн эзний зөвшөөрөл цуцлагдана.

ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОСОН:

Огноо:

Гарын үсэг: